

## **ВИРТУАЛ ХӨРӨНГӨ БҮРТГЭЛИЙН ШААРДЛАГА, ШАЛГУУР, ДҮРЭМ, ЖУРАМ**

Виртуал хөрөнгийг бүртгэх үед Бирж нь “Капекс ВХҮҮ-ийн Виртуал хөрөнгийг бүртгэх, бүртгэлээс хасах, арилжааг түр зогсоох журам”-ын дагуу дараах мэдээллийг авна. Үүнд:

- Биржид бүртгүүлэхээр хүсэлт гаргагч нь дараах зохих шалгуурыг хангаж буй талаар нотлох баримтыг ирүүлнэ. Үүнд:
- Өөрийн бүртгэлтэй улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан байх ба компанийн дүрэм, үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцсэн талаар зохих этгээдийн тодорхойлолт, дүгнэлт;
- Өргөдөл гаргахаас өмнөх зохих хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх шалгуурыг хангаж байгааг батлах баримт;
- Крипто гаргагч, ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирал нь татварын болон хугацаа хэтэрсэн их хэмжээний зээлийн өргүй талаарх зохих этгээдийн тодорхойлолт, Хэрэв өртэй тохиолдолд өр зээлийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг криптовалютын whitepaper-т тусгасан байх;
- Компанийн эрх бүхий албан тушаалтнуудын дэлгэрэнгүй анкет, үйл ажиллагаа явуулахад шаардагдах хангалттай туршлагатайг батлах баримт, тэдгээрийг томилсон шийдвэр;
- Криптовалют хариуцсан ажилтны мэдээлэл /анкет/;
- Криптовалютыг арилжаанд оруулах өдөр тус компанийн зах зээлийн үнэлгээ нь биржээс тухай бүр тогтоосон шаардлагыг хангах боломжтой болохыг тодорхойлох баримт;
- Криптовалютыг олон нийтэд санал болгон гаргах доод хэмжээг хангах боломжтой талаар нотлох баримт;
- Бүртгүүлэх криптовалют нь барьцаалагдах зэргээр гуравдагч этгээдийн эрхээр үүрэгжээгүй, битүүмжлэгдээгүй, өмчлөх эрхийг шилжүүлэхэд аливаа хязгаарлалтгүй, чөлөөтэй шилжих, арилжигдах боломжтой болохыг нотлох баримт;
- Криптовалютыг бүртгүүлэх тухай өргөдөл, whitepaper-т крипто гаргагчийн ТУЗ-ийн дарга, Гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга эсхүл ерөнхий нягтлан бодогч гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулсан байна.
- Криптовалютыг бүртгүүлэх хүсэлтэд дараах бичиг баримтыг хавсаргана. Үүнд:
- Бүртгүүлэх өргөдөл /Маягт 1/
- Крипто гаргагчийн мэдэгдэл /Маягт 2/
- СЗХ-ны ВХҮҮ-ийн үйл ажиллагааны журмын 5.3-д тусгасан тодорхойлолт баримт бичгүүд бүрдүүлсэн байна;
- Криптовалютын whitepaper<sup>1</sup> танилцуулгад СЗХ-ны ВХҮҮ-ийн үйл ажиллагааны журмын 5.4-д тусгасан мэдээллийг агуулсан байна;
- Криптовалютыг хаалттай хүрээнд буюу нэр зааж эзэмшүүлэх бол үндэслэл шалтгааны тайлбар;
- Крипто гаргагчаас бусадтай байгуулсан их хэмжээний гэрээ хэлцэл, өр, зээл, барьцаа, баталгаа гаргасан бол түүний талаар баримт;

---

<sup>1</sup> Whitepaper нь криптовалютын үйл ажиллагааны талаарх мэдээллийг агуулсан баримт бичиг юм.

- Криптовалютын найдвартай байдлыг хангахтай холбоотой барьцаа баталгааны баримт;
- Биржээс шаардлагатай гэж үзсэн бусад материал;
- Бирж нь крипто гаргагчийн криптовалютыг биржийн бүртгэлд бүртгэхэд дараах үнэлгээний зарчимд үндэслэнэ. Үүнд:
  - Криптовалют, түүний төсөл нь эдийн засгийн үр ашигтай, бодитой, хэрэгжихүйц эсэх
  - Криптовалютын суурилсан блокчэйн нь бүрэн хөгжүүлэлт хийгдэж, кибер аюулгүй байдлыг хангасан ба цаашид доголдолгүй ажиллаж, сайжруулж хөгжүүлэх боломжтой эсэх
  - Криптовалютын ялгарал буюу тухайн криптовалютын ялгарал, технологийн дэвшилтэт шийдэл, иноваци, нийгэмд үзүүлэх нөлөө
  - Криптовалютын төслийн урт дунд хугацааны зорилго, зорилтот алхмууд, асуудал шийдвэрлэх механизм
  - Бизнес модел буюу Криптовалютын төслийн бизнес модел буюу орлого, зарлагын төлөвлөгөө, учирч болох эрсдэлүүд
  - Үүсгэн байгуулагч буюу Криптовалютын төслийг үүсгэн байгуулсан компани, хамт олны чадвар, туршлага
  - Prototype буюу Төсөл нь testnet эсвэл mainnet дээр хэрэгжих боломжтой байх, аюулгүй байдал буюу Доголдол (bugs), эмзэг байдлыг тогтмол засварлаж байх, эх кодыг дайралтад өртөхгүй байх арга хэмжээ авч хэрэгжүүлэх чадамжтай эсэх
  - Крипто гаргагч болон криптовалютын төсөл нь холбогдох хууль эрх зүйн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг байх, биржийн нийцлийн журам, бодлогыг хүлээн зөвшөөрөх
  - Крипто гаргагч нь санхүү болон технологийн хөндлөнгийн аудит хийлгэсэн эсэх
  - Зах зээлийн үнэлгээ буюу Криптовалютын ИЕО хийх үеийн нэгжийн үнэ, зах зээлд идэвхитэй байгаа тоо ширхэг, нийт нийлүүлэлт, зах зээлийн үнэлгээ
  - Арилжааны идэвхи буюу Криптовалютын арилжааны хэмжээ, идэвхитэй арилжаалдаг хэрэглэгчдийн тоо, идэвхитэй арилжаалагддаг тоо хэмжээ
  - Коммунити буюу Криптовалютын төслийг дэмжигч коммунити, социал медиа, мэдээлэл түгээх суваг
  - Маркетинг буюу Криптовалют гаргарчийн төслөө сурталчлах, хэрэглээг нэмэгдүүлэх, маркетинг, PR, эвент хөтөлбөрүүд